

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/010/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: Л.Отгон Утас: 99059489 Цахим хаяг: devjikhcapital.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/010/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13.
Цахим шуудан: govial:ai@audit.gov.mn

2025. 02.24 № 98

танай _____-ны № _____-т

**БИГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Н.БУЛГАН ТАНАА**

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.4, 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Монгол Улс Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралт "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

8225020246

- Төсөв захирагчийн хамаарал бүхий этгээдийн компаниас 100 жилийн ойгоор хүнсний материал 19,477.7 мянган төгрөг, гэр интернэт болон хангамжийн материалд 2,514.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн,
- Ёс зүйн хорооны гишүүдэд сар бүр цалингийн нэмэгдэл хэлбэрээр 1,704.2 мянган төгрөгийг олгосон,
- Батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү ажиллуулж, 2,681.9 мянган төгрөгийн цалинг төсвөөс олгосон,
- Цахим дэлгүүрээс 6,264.1 мянган төгрөгийн компьютер, 4,800.0 мянган төгрөгийн тавилга худалдан авалт хийгээгүй;
- Тайлант онд дансанд бүртгэлтэй 22,000.0 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй, тооцсо бодож баталгаажуулаагүй,
- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 6,440.0 мянган төгрөгийг тэмцээн уралдаанд зориулалт бусаар зарцуулсан.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Тайлант онд сумын 100 жилийн ой тохиосон байна. Сумын 100 жилийн ойн дэмжлэгээр олгосон санхүүжилтээс ойн арга хэмжээний асар, гэрэлтүүлэг, нэвтрүүлэг болон бусад бүтээгдэхүүн худалдан авахад 68,977.3 мянган төгрөгийг зарцуулсан, цаг уурын барилгын 70 хувь болох 19,810.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Иргэд болон аж ахуйн нэгж, орон нутгийн хөгжлийн сангаас 575,647.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хандиваар хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 957,615.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж бүрэн авсан байна.

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 357,504.9 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс, нэг удаагийн тэтгэвэр тэтгэмж, тээвэр шатахуун, хангамж, бараа материалын зардал нэмэгдсэнтэй холбоотой.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 7 зорилт 182 арга хэмжээ хэрэгжүүлэхээр сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 83.3 хувьтай үнэлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд "Нээлттэй Алтай" хөтөлбөрийн үр дүнгээр шинээр гэр бүл болсон 6 залуу малчин өрхөд тус бүр 50 толгой бог малаар малжуулах ажлыг зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	282,958,468.20	257,828,979.16
33	АВЛАГА	127,034,706.00	106,305,353.96
33500	Бусад авлага	127,034,706.00	106,305,353.96
33510	Байгууллагаас авах авлага	127,034,706.00	106,305,353.96
35	БАРАА МАТЕРИАЛ	123,623,762.20	130,223,625.20
35100	Түүхий эд материал	6,000,000.00	6,000,000.00
35110	Тусгай зориулалттай материал	6,000,000.00	6,000,000.00
35400	Хангамжийн материал	26,423,762.20	31,923,625.20
35410	Бичиг хэргийн материал	1,781,450.00	3,156,075.00
35420	Аж ахуйн материал	3,782,565.00	8,713,565.00
35440	Түлш, шатах тослох материал	253,047.20	1,187,885.20
35450	Барилгын засварын материал	10,100,000.00	8,630,000.00
35470	Бусад хангамжийн материал	10,506,700.00	10,236,100.00
35600	Мал амьтад	91,200,000.00	92,300,000.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	32,300,000.00	21,300,000.00
36900	БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	32,300,000.00	21,300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,602,866,532.40	3,011,174,370.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,602,866,532.40	3,011,174,370.99
39200	Биет хөрөнгө	2,533,242,210.51	2,939,706,537.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,438,020,532.07	1,726,100,032.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	(346,754,965.55)	(404,359,302.29)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	129,536,000.00	156,397,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(93,973,377.86)	(66,652,925.24)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	113,728,079.00	156,068,171.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,278,205.31)	(97,548,271.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,740,574.72	37,929,574.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,769,562.46)	(20,358,021.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,776,022,226.00	2,131,725,655.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(409,029,090.10)	(679,595,375.09)
39300	Биет бус хөрөнгө	69,624,321.89	71,467,833.33
39301	Програм хангамж	1,980,000.00	3,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,692,678.11)	(1,849,166.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	69,337,000.00	69,337,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,885,825,000.60	3,269,003,350.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,885,825,000.60	3,269,003,350.15
51	Засгийн газрын хувь оролцоо	2,885,825,000.60	3,269,003,350.15
51100	Засгийн газрын оруулсан капитал	257,131,132.14	257,131,132.14
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	257,131,132.14	257,131,132.14
51200	Хуримтлагдсан үр дүн	2,333,055,059.11	2,716,233,408.66
51210	Өмнөх үеийн үр дүн	2,229,332,488.78	2,333,055,059.11
51220	Тайлант үеийн үр дүн	103,722,570.33	383,178,349.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	295,638,809.35	295,638,809.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,885,825,000.60	3,269,003,350.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,062,863,709.00	2,021,114,385.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	385,404,662.00	779,935,829.00
120	Нийтлэг татварын бус орлого	385,404,662.00	779,935,829.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	271,543,500.00	778,247,829.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	24,100,000.00	1,688,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	677,459,047.00	1,241,178,556.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,348,947.00	283,563,556.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,007,801.00	277,493,557.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,206,492.00	6,069,999.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	582,110,100.00	957,615,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	582,110,100.00	957,615,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	958,277,838.67	1,624,014,167.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	958,277,838.67	1,624,014,167.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	898,170,501.97	1,490,890,482.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,122,280.00	651,241,817.00
210101	Үндсэн цалин	257,865,145.00	275,856,265.00
210102	Нэмэгдэл	80,532,500.00	269,767,677.00
210104	Урамшуулал	0	27,660,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,724,635.00	77,957,675.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,211,068.37	80,000,393.42
210201	Тэтгэврийн даатгал	35,780,668.37	56,480,693.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,857,600.00	6,129,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,286,100.00	3,903,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	571,400.00	1,226,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,715,300.00	12,259,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,960,208.32	17,062,990.89
210301	Гэрэл, цахилгаан	4,364,608.32	5,632,990.89
210302	Түлш, халаалт	12,565,600.00	11,380,000.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,746,594.80	32,618,397.00
210401	Бичиг хэрэг	2,702,860.00	3,613,375.00
210402	Тээвэр, шатахуун	13,461,374.80	15,467,022.00
210403	Шуудан, холбос, интернэтийн төлбөр	1,687,600.00	1,488,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,686,200.00	1,049,300.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	0	11,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,443,200.00	11,045,400.00
210604	Урсгал засвар	2,443,200.00	11,045,400.00
2107	Томилолт, зочны зардал	8,146,000.00	8,560,000.00
210702	Дотоод албан томилолт	8,146,000.00	8,560,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,749,242.00	2,565,275.00
210803	Даатгалын үйлчилгээ	280,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,388.00	334,685.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	131,300.00
210807	Газрын төлбөр	841,854.00	746,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	1,152,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	411,791,908.48	687,796,209.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,875,449.00	319,843,294.50

Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	345,916,459.48	367,352,914.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,107,336.70	133,123,685.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,617,800.00	103,464,768.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	31,637,768.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,597,800.00	69,537,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,020,000.00	2,290,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,489,536.70	29,658,917.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,489,536.70	29,658,917.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	104,585,870.33	397,100,217.18
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	863,300.00	13,921,867.63
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	13,651,267.63
225011	Үнэ төлбөргүй гэрсан зардал - Бараа материал	863,300.00	270,600.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	103,722,570.33	383,178,349.55

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	708,672,930.39	1,305,836,262.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	708,672,930.39	1,305,836,262.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,562,830.39	348,221,262.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,134,654.00	64,657,706.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,221,684.39	277,493,557.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,206,492.00	6,069,999.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	582,110,100.00	957,615,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	582,110,100.00	957,615,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	689,682,930.39	1,291,272,070.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	689,682,930.39	1,291,272,070.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	564,917,887.69	1,113,966,030.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,376,280.00	650,987,817.00
210101	Үндсэн цалин	258,119,145.00	275,602,265.00
210102	Нэмэгдэл	80,532,500.00	269,767,677.00
210104	Урамшуулал	-	27,660,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,724,635.00	77,957,675.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,131,268.37	80,000,393.42
210201	Тэтгэврийн даатгал	35,700,868.37	56,480,693.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,857,600.00	6,129,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,286,100.00	3,903,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	571,400.00	1,226,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,715,300.00	12,259,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,556,208.32	17,062,990.89
210301	Гэрэл, цахилгаан	4,364,608.32	5,632,990.89
210302	Түлш, халаалт	11,161,600.00	11,380,000.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,109,240.00	23,886,860.00
210401	Бичиг хэрэг	4,199,260.00	4,951,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,621,320.00	16,401,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,687,600.00	1,488,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,392,500.00	1,045,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,997,200.00	9,575,400.00
210604	Урсгал засвар	3,997,200.00	9,575,400.00

Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	8,146,000.00	8,560,000.00
210702	Дотоод албан томилолт	8,146,000.00	8,560,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,749,242.00	2,565,275.00
210803	Даатгалын үйлчилгээ	280,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,388.00	334,685.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	131,300.00
210807	Газрын төлбөр	841,854.00	746,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	1,152,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,852,449.00	321,327,294.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,852,449.00	320,567,294.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	760,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,765,042.70	177,306,039.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,617,800.00	103,464,768.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	31,637,768.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,597,800.00	69,537,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,020,000.00	2,290,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	82,147,242.70	73,841,271.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,489,536.70	29,658,917.23
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	64,657,706.00	44,182,353.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	18,990,000.00	14,564,192.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,990,000.00	14,564,192.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,990,000.00	14,564,192.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,990,000.00	14,564,192.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,990,000.00	14,564,192.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(18,990,000.00)	(14,564,192.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,229,332,488.78	2,782,102,430.27
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,229,332,488.78	2,782,102,430.27
9	Тайлант үеийн үр дүн	-	-	103,722,570.33	103,722,570.33
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,333,055,059.11	2,885,825,000.60
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,333,055,059.11	2,885,825,000.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,333,055,059.11	2,885,825,000.60
19	Тайлант үеийн үр дүн	-	-	383,178,349.55	383,178,349.55
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,716,233,408.66	3,269,003,350.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	957,615,000.00	927,956,082.77	29,658,917.23	96.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	957,615,000.00	927,956,082.77	29,658,917.23	96.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	851,278,000.00	824,491,314.77	26,786,685.23	96.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	657,213,200.00	650,987,817.00	6,225,383.00	99.05
210101	Үндсэн цалин	279,679,000.00	275,602,265.00	4,076,735.00	98.54
210102	Нэмэгдэл	270,652,000.00	269,767,677.00	884,323.00	99.67
210104	Урамшуулал	27,660,200.00	27,660,200.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	79,222,000.00	77,957,675.00	1,264,325.00	98.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,322,000.00	80,000,393.42	2,321,606.58	97.18
210201	Тэтгэврийн даатгал	57,802,000.00	56,480,693.42	1,321,306.58	97.71
210202	Тэтгэмжийн даатгал	6,130,000.00	6,129,900.00	100.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,904,000.00	3,903,900.00	1,000,100.00	79.61
210204	Ажилгүйдлийн даатгал	1,226,000.00	1,226,000.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,260,000.00	12,259,900.00	100.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,850,000.00	15,049,222.85	3,800,777.15	79.84
210301	Гэрэл, цахилгаан	3,750,000.00	3,619,222.85	130,777.15	96.51
210302	Түлш, халаалт	15,000,000.00	11,380,000.00	3,620,000.00	75.87
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	50,000.00	50,000.00	50.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,131,000.00	21,767,740.00	3,363,260.00	86.62
210401	Бичиг хэрэг	4,951,000.00	4,951,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	16,286,000.00	14,282,740.00	2,003,260.00	87.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,488,700.00	11,300.00	99.25
210404	Ном, хэвлэл	500,000.00	0	0	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	0	0	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,794,000.00	1,045,300.00	748,700.00	58.27
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,000,000.00	20,299,592.00	5,700,408.00	78.08
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,800,000.00	10,724,192.00	3,075,808.00	77.71
210604	Урсгал засвар	12,200,000.00	9,575,400.00	2,624,600.00	78.49
2107	Томилолт, зочны зардал	12,192,000.00	8,560,000.00	3,632,000.00	70.21
210702	Дотоод албан томилолт	12,192,000.00	8,560,000.00	3,632,000.00	70.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,670,000.00	2,565,275.00	104,725.00	96.08
210803	Даатгалын үйлчилгээ	269,000.00	200,000.00	69,000.00	74.35
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347,600.00	334,685.00	12,915.00	96.28
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	131,300.00	22,700.00	85.26
210807	Газрын төлбөр	746,400.00	746,400.00	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,153,000.00	1,152,890.00	110.00	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,899,800.00	25,261,274.50	1,638,525.50	93.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,899,800.00	24,501,274.50	1,398,525.50	94.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	760,000.00	240,000.00	76.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,337,000.00	103,464,768.00	2,872,232.00	97.30

Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	106,337,000.00	103,464,768.00	2,872,232.00	97.30
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	33,000,000.00	31,637,768.00	1,362,232.00	95.87
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,537,000.00	69,537,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,800,000.00	2,290,000.00	1,510,000.00	60.26
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	957,615,000.00	927,956,082.77	29,658,917.23	96.90
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	957,615,000.00	927,956,082.77	29,658,917.23	96.90
320001	Орон нутгийн төсвөөс	957,615,000.00	927,956,082.77	29,658,917.23	96.90
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	25	1	96.15
620001	Удирдах ажилтан	9	9	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	100.00
620004	Гэрээт ажилтан	4	3	1	75.00

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	126,562,830.39	304,038,908.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,562,830.39	304,038,908.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,905,124.39	304,038,908.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,150,705.39	2,013,768.04
210301	Гэрэл, цахилгаан	1,150,705.39	2,013,768.04
2104	Хангамж, бараа материалын зардал	988,800.00	2,119,120.00
210402	Тээвэр, шатахуун	988,800.00	2,119,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,765,619.00	299,906,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,765,619.00	299,906,020.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	126,562,830.39	348,221,262.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,562,830.39	348,221,262.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,134,654.00	64,657,706.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,221,684.39	277,493,557.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,206,492.00	6,069,999.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	44,182,353.96

Гурав. Аудитын илрүүлэлт:

Залруулагдаагүй нийт 65,882.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, харилцан хамааралтай этгээдээс худалдан авалт хийсэн тул "Сөрөг" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 65,882.4 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрч 65,882.4 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Албан шаардлага

1. ЗДТГ-ын даргын хамаарал бүхий этгээдийн компаниас 100 жилийн ойн төсвөөс 19,477.7 мянган төгрөг, шуудан холбоо болон хангамжийн материалд 2,514.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Ёс зүйн хорооны гишүүдэд сар бүр цалингийн нэмэгдэл хэлбэрээр 1,704.2 мянган төгрөгийг олгосон нь Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолийн хавсралт "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8-т "5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгоно. 3 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшууллыг улирал тутамд олгоно" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын гүйцэтгэл харгалзахгүй сар бүр урамшуулал олгож буй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант онд 11,064.1 мянган төгрөгийн компьютер, бусад хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд данс бүртгэлд бүртгэлтэй 22,000.0 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Бараа материалын тооллогыг зохих хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн

5. Батлагдсан орон тооноос 1 орон тоог илүү ажиллуулан 2,681.9 мянган төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт ба таан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"; 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 16.5.9-т "дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

6. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 6,440.0 мянган төгрөгийг тэмцээн уралдаан зохион байгуулахад зориулалт бусаар зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

(мянган төгрөгөөр)

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	6	65,382.4			6	65,882.4	-	-	-	-	-	-
Дүн	6	65,382.4			6	65,882.4	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1					1	
	НИЙТ		1					1	